



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 1180

Шивээговь сум

Шүдний кабинетын тоног төхөөрөмж
хүлээн авах ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 255 дугаар “Үндэсний хөтөлбөр батлах тухай” тогтоол, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Эрүүл шүд - Эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөр, сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрүүл мэндийн яамтай хамтран сумын Эрүүл мэндийн төвд шүдний кабинет шинээр байгуулсантай болсонтой холбогдуулан тоног төхөөрөмжийг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:

Ч.Сугармаа

(Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга:

Х.Сувданцэцэг

(Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Д.Сувд-Эрдэнэ

(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Г.Бум-Аюуш

(Эрүүл мэндийн төвийн Нягтлан бодогч)

Б.Энхцэцэг

(Эрүүл мэндийн төвийн нярав)

2. Тоног төхөрөмжийг ажлын тоо хэмжээний дагуу бүрэн бүтэн байдлыг шалгаж, хүлээн авахыг /Ажлын хэсэг/-т үүрэг болгосугай.

42121 453

3. Шүдний кабинетын тоног төхөөрөмжийг байгууллагын хөрөнгөнд бүртгэн орлогодож авахыг Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч /Г.Бум-Аюуш/, нярав /Б.Энхцэцэг/, хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж, хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, хариуцан ажиллахыг Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Сувданцэцэг/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ